



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН



РОССИЙСКИЙ
ЭТНОГРАФИЧЕСКИЙ
МУЗЕЙ

МОНГОЛ ОРОН МОНГОЛЧУУД

«Д.Э.Ухтомскийн 1913 оны экспедициин дуранд тодорсон Умард Монгол.
Оросын Угсаатны Зүйн музейн гэрэл зургийн цуглуулга»

ЭМХЭТГЭСЭН: М.В. ФЕДОРОВА, К.Ю. СОЛОВЬЕВА, С.ЧУЛУУН



МОНГОЛИА И МОНГОЛЫ

«Северная Монголия в объективе экспедиции Д.Э. Ухтомского. Каталог
коллекций Российского этнографического музея»

СОСТАВИТЕЛИ: ФЕДОРОВА М.В., СОЛОВЬЕВА К.Ю., ЧУЛУУН С.

Улаанбаатар
2020

**Зохиогчид:**

Федорова М.В. — төслийн эрдэм шинжилгээний удирдагч, зохиогч

Соловьева К.Ю. — зохиогч

Ажлын хэсэг:

Прокопьева Н.Н. — төслийн удирдагч

Островский А.Б. — эрдэм шинжилгээний редактор

Чистякова Ж.К. — зохицуулагч

Белобородова И.В.

Галахова М.Ю.

Ганичева О.В.

Кононова Е.Ф.

Копанева А.Н.

Любимова А.А.

Христенко А.В.

Черенкова Л.Г.

Зохиогчид:

Федорова Марина Владиславовна, Оросын Угсаатны зүйн музейн Сибирь, Алс дорнодын ард түмнүүдийн угсаатны зүйн салбарын тэргүүлэх эрдэм шинжилгээний ажилтан 1987 оноос тус музейд ажиллаж буй. Ленинградын улсын их сургуулийн түүхийн тэнхимд суралцан төгсч, Оросын Угсаатны зүйн музейн аспирантурыг дүүргэсэн. XIX-XX зууны Сибирь, Алс дорнодын ард түмнүүдийн соёлын үнэт зүйлс, ахуйн эд хэрэгслийн мэргэжилтэн, Оросын Төвд Гималай судлалын холбооны гишүүн. Судалгааны чиглэл: Оросын болон Төв Азийн монгол хэлт ард түмнүүдийн уламжлалт соёл. Орос болон хилийн чанадад үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал, соён гэгээрүүлэх, хэвлэн нийтлэх олон тооны төсөлд оролцож байсан. Сибирийн ард түмнүүд болон халимаг, монголчуудын угсаатны зүйн холбогдолтой (бэлгэдэл зүй, ангилал, гарал зүй, уламжлалт хувцас чимэглэлийн хээ угалз судлал, төмөрлөгийн урлал, гар урлал, Орос болон Азийн ард түмний соёл дахь буддизм, Оросын Угсаатны зүйн музейн цуглуулгын түүх) 70 гаруй бүтээл нийтлүүлжээ.

Соловьева Карина Юрьевна, Оросын Угсаатны зүйн музейн Гэрэл зургийн салбарын эрхлэгч, 1981 оноос хойш музейд ажиллаж буй. А.А. Ждановын нэрэмжит Ленинградын улсын их сургуулийн урлагийн түүхийн тэнхимд суралцаж төгссөн, Санкт-Петербургийн их сургуулийн гүн ухааны тэнхимийн аспирантурыг дүүргэжээ. ОХУ-ын соёлын гавьяат зүтгэлтэн. 2018 онд ЮНЕСКО-гийн “Хоол хүнс” шинжээчийн хэсгийн гишүүн болжээ. 1981-2003 онд Сибирь, Алс дорнодын салбарт ажиллаж, 1995-2004 онд Технологи, дизайны их сургуульд багшлах. 2005 оноос Гэрэл зургийн салбарын эрлэгчээр ажиллаж байна. Орос болон хилийн чанадад үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал, соён гэгээрүүлэх, хэвлэн нийтлэх олон тооны төсөлд оролцож байсан. Сибирийн ард түмнүүдийн угсаатны зүй (фин-угрчууд, бөө мөргөл, Сибирь, Алс дорнодын ард түмнүүдийн уламжлалт ахуй соёл, угсаатны зүй), Оросын эрт үеийн гэрэл зургийн түүхэн дэх угсаатны зүйн судалгаа болон угсаатны зүйн гэрэл зургийн тухай 50 гаруй бүтээл нийтлүүлжээ.

Авторы:

Федорова М.В. — научный руководитель проекта, автор
Соловьева К.Ю. — автор

Рабочая группа:

Прокопьева Н.Н. — руководитель проекта

Островский А.Б. — науч. ред.

Чистякова Ж.К. — координатор

Белобородова И.В.

Галахова М.Ю.

Ганичева О.В.

Кононова Е.Ф.

Копанева А.Н.

Любимова А.А.

Христенко А.В.

Черенкова Л.Г.

Авторы:

Федорова Марина Владиславовна, ведущий научный сотрудник Отдела этнографии народов Сибири и Дальнего Востока Российского этнографического музея, работает в музее с 1987 г. Окончила исторический факультет ЛГУ, а также аспирантуру РЭМ. Эксперт по культурным ценностям: предметы быта (народы Сибири и Дальнего Востока, кон. XIX — XX вв.), член Российской ассоциации исследователей Гималаев и Тибета. Тематика научных исследований: традиционная культура монголоязычных народов России и Центральной Азии. Автор и участник выставочных, издательских, научно-исследовательских и научно-просветительских проектов и конференций в России и за рубежом. Автор более 70 научных публикаций по этнографии народов Сибири, калмыков и монголов, буддизму в культуре народов России и зарубежной Азии, истории комплектования коллекций РЭМ.

Соловьева Карина Юрьевна, заведующая Отделом Фотографии, работает в музее с 1981 года. Окончила исторический факультет ЛГУ им. А.А. Жданова кафедры истории искусства, также аспирантуру философского факультета СПбГУ. Заслуженный работник культуры РФ. В 2018 г. - член экспертной группы “Пища и гастрономия” ЮНЕСКО. С 1981 по 2003 год работала в отделе этнографии народов Сибири и Дальнего Востока, с 2005 года - заведующая Отделом фотографии. Тематика научных исследований и интересов: традиционная культура обских угров, шаманизм, традиционное искусство народов Сибири и Дальнего Востока, визуальная антропология, история этнографической фотографии в контексте собрания РЭМ. Автор выставочных, издательских, научных и научно-просветительских проектов как в России, так и за рубежом; участник 12 этнографических экспедиций в Западную Сибирь, Республику Саха (Якутия). Автор более 50 научных и научно-популярных публикаций, книг по традиционной культуре народов Сибири и Дальнего Востока, истории этнографической фотографии и этнографических исследований в визуальных источниках.

Оросын Угсаатны зүйн музейн болон Монгол Улсын ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн зөвшөөрлөөр хэвлэн нийтлүүлэв.

Энэхүү цомогт Оросын дорно дахин судлал, музей судлалын хамгийн тод боловч бага судлагдсан нэгэн хуудас болох Эзэн хаан III Александрын Оросын музейн Угсаатны зүйн салбарын ажилтан Дий Эсперович Ухтомскийн 1913 онд Умард Монголд удирдан явсан экспедицийн түүхийг дэлгэрэнгүй үзүүлнэ. Дорно дахины ард түмнүүдийн уламжлалт соёлыг харуулсан цуглуулга бүрдүүлэх нь XX зууны эхэн үеийн Оросын музейн Угсаатны зүйн салбарын (эдүгээ Оросын угсаатны зүйн музей болсон) судалгаа шинжилгээний нэгэн гол чиглэл байсан юм. Угсаатны зүйч Д.Э.Ухтомскийн удирдан Умард Монголд явуулсан экспедицийн үеэр буулгасан энэхүү гэрэл зургийн цомог нь Оросын Угсаатны зүйн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй монголчуудын уламжлалт соёлыг харуулсан цуглуулгын дээжис нь гэж хэлж болох юм. Үйл явдал, газар орон, зураг авсан хүнийг нь тодорхойлсон 220 гэрэл зураг ийнхүү анх удаагаа хэвлэгдэж байна. Тус цомгийг Монгол орны уламжлалт соёл, түүхийг сонирхон судлагч хэн бүхэн төдийгүй Оросын угсаатны зүйн шинжлэх ухааны түүх, дорно дахин судлаач Дий Эсперович Ухтомский лугаа танилцахыг хүссэн өргөн олон уншигчдад зориулав.

Түлхүүр үг: Д.Э.Ухтомский, Монгол дахь угсаатны зүйн судалгаа, монголчуудын уламжлалт соёл, угсаатны зүйн гэрэл зураг, гэрэл зургийн цуглуулга, Оросын угсаатны зүйн музей, Оросын музейн Угсаатны зүйн салбар.

Ерөнхий редактор: С.Чулуун
 Эмхэтгэсэн: М.В. Федорова, К.Ю. Соловьева, С.Чулуун
 Орчуулагч: Б.Нацагдорж
 Техник редактор: С.Амарбаяр
 Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Б.Баясгалан
 Хэвлэлийн хуудас: 37
 Хэвлэлийн газар: Адмон принтинг ХХК
 Хэвлэсэн тоо: 300 ширхэг

Книга издается по решению Ученого Совета Русского Этнографического Музея и Ученого Совета Института истории и этнографии МАН.

Альбом посвящен одной из ярких и до сих пор малоизвестных страниц российского востоковедения и музееведения: истории экспедиции 1913 года в Северную Монголию сотрудника ЭО Русского музея императора Александра III Дия Эсперовича Ухтомского. Сбор и изучение коллекций по традиционной культуре народов зарубежного Востока были одними из важных направлений работы ЭО Русского музея (в настоящее время – Российского этнографического музея) в начале XX века. В альбоме рассказывается об этнографе Д.Э. Ухтомском, о возглавляемой им экспедиции в Северную Монголию и созданных в ходе ее осуществления фотоколлекциях, которые являются жемчужиной фотографического собрания по традиционной культуре монголов РЭМ. Впервые публикуются 220 фотографий с расширенными аннотациями, описаниями сюжетов и атрибуцией, позволившей установить авторство каждого снимка. Данное издание адресовано широкому кругу читателей, которые, несомненно, откроют для себя не только новые страницы истории российской науки, но и познакомятся с удивительно яркой личностью и выдающимся знатоком культуры Востока Дием Эсперовичем Ухтомским.

Ключевые слова: Д.Э. Ухтомский, этнографические экспедиции в Монголию, традиционная культура монголов, этнографическая фотография, фотоколлекции, Российский этнографический музей, Этнографический отдел Русского музея.

Главный редактор: Чулуун С.
 Составители: Федорова М.В., Соловьева К.Ю. Чулуун С.
 Переводчик: Нацагдорж Б.
 Технический редактор: Амарбаяр С.
 Компьютерная верстка: Баясгалан Б.
 Печатный лист: 37
 Издательство: Адмон принтинг ХХК
 Тираж: 300 экз.

Авторское право на эту книгу защищается на законной основе и никакая часть данной публикации не может быть воспроизведена или передана в любой форме или любыми средствами, включая фотокопирование, запись, или другие электронные или механические методы без разрешения.

ГАРЧИГ

- МЭНДЧИЛГЭЭ 6
- ӨМНӨХ ҮГ 8
- 1913 ОНД УМАРД МОНГОЛД Д.Э.УХТОМСКИЙН ЯВУУЛСАН ЭКСПЕДИЦ 10
- Д.Э.УХТОМСКИЙН 1913 ОНЫ ЭКСПЕДИЦИИН ДУРАНД ТОДОРСОН УМАРД МОНГОЛ 34
- ХҮМҮҮСИЙН НЭР 265
- ОРОСЫН УГСААТНЫ ЗҮЙН МУЗЕЙН АРХИВТ ХАДГАЛАГДАЖ БҮЙ Д.Э.УХТОМСКИЙН 1913 ОНД МОНГОЛД ЯВУУЛСАН ЭКСПЕДИЦ БОЛОН ЭКСПЕДИЦИЙН ГИШҮҮДЭД ХОЛБОГДОХ БАРИМТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ 275
- ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 276
- ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦЭС 277

ОГЛАВЛЕНИЕ

- ПРИВЕТСТВЕННОЕ СЛОВО 7
- ПРЕДИСЛОВИЕ 9
- ЭКСПЕДИЦИЯ Д.Э. УХТОМСКОГО В СЕВЕРНУЮ МОНГОЛИЮ 1913 Г. 20
- СЕВЕРНАЯ МОНГОЛИЯ В ОБЪЕКТИВЕ ЭКСПЕДИЦИИ Д.Э. УХТОМСКОГО 1913 Г. 34
- ПЕРСОНАЛИИ 269
- ГЛОССАРИЙ 273
- СПИСОК МАТЕРИАЛОВ АРХИВА РЭМ, ОТНОСЯЩИХСЯ К ЭКСПЕДИЦИИ Д. Э. УХТОМСКОГО В МОНГОЛИЮ В 1913 Г. И ЕЁ УЧАСТНИКАМ 275
- СПИСОК СОКРАЩЕНИЙ 276
- КАТАЛОГ ФОТОГРАФИЙ 277



МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм нөхөд минь,

Оросын Угсаатны зүйн музей нь, анх үүсгэлээсээ аваад л олон хэлийн ард түмний өв соёлыг хадгалж үлдээх эрхэм зорилготой явж ирсэн билээ. Эдүгээ манай музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Орос болон түүний эргэн тойрны хөрш ард түмний соёлыг илэрхийлэн харуулсан 530 мянга гаруй хадгаламжийн нэгж үзмэрүүд нь, Оросын Угсаатны зүйн музейг Дэлхийн аварга том угсаатны зүйн музейнүүдийн эгнээнд зүй ёсоор оруулдаг юм.

Оросын Угсаатны зүйн музей нь өнөөдөр дэлхий дахины олон олон соёлын байгууллагуудын адилаар энэхүү баялаг өвөө хойч үед хадгалан үлдээхийн хамт өргөн олон түмэнд тал бүрээр хүртээлтэй хүрч ажиллах хэцүүхэн зорилтыг биелүүлэхээр ажиллаж байна. Бид бүхэн музейн цуглуулгуудаа найдвартай хадгалж, хамгаалахын зэрэгцээ тэднийг хүн бүрд хүртээмжтэй болгохоор чармайн ажилласнаар дэлхий дахинд ганц музейнхээ төдийгүй эх орныхоо ч гэсэн ил тод байдлын бэлгэ тэмдэг нь болох юмсан хэмээн хичээдэг. Энэ хичээл зүтгэл маань музейнхээ ховор нандин цуглуулгуудыг хадгалж хамгаалан, дэлхий дахины мэдээллийн сан хөмрөгт музейн эх сурвалжуудыг оруулах гол тулгуур зарчим болдог юм. Тиймээс цуглуулгын каталогуудыг эрхлэн хэвлүүлэхэд музейн зүгээс онцгой анхаарч ирсэн билээ.

Тухайн газар оронд нь очиж цуглуулж бүрдүүлсэн цуглуулгуудаа тэр улс орны ард түмэнд зориулан танилцуулах нь, орчин үеийн угсаатны зүйн музейн хүндтэй бөгөөд тэргүүн зорилт байх юм. Иймийн учир, энэхүү каталогийг бэлдэж хэвлүүлэхэд харамгүй ач тусаа хүргэсэн Монголын Шинжлэх Ухааны Академийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн удирдлага болоод эрдэм шинжилгээний ажилтнуудад гүнээ талархаж байна.

Хоёр байгууллагын хамтарсан төслийн хүрээнд 1913 онд Монголд аялсан Д.Э.Ухтомскийн экспедицийн эрдэм шинжилгээний өв болон түүний буулгасан гэрэл зургуудыг эрдэм шинжилгээний тайлбар сэлтийн хамт хэвлүүлсэн нь, энэхүү каталогийн эрдэм шинжилгээ, түүхэн сурвалжийн үнэ цэнийг нь өндөрт өргөж байгаа юм.

Ингээд өнөө цагийн манай хоёр улсын хоорондох соёл, хүмүүнлэгийн харилцааг хөгжүүлэхэд ач тустай, эртний уламжлалтай Орос-Монголын соёлын өвийн шинэ өнцгийг нээн харуулсан манай хамтын ажлын туршлага, үр дүнгээ бид дэлхий дахинаа баяртайгаар танилцуулж, Монгол орны түүх соёлын өвийг танин мэдэж, хадгалан хамгаалахад оруулсан Оросын судлаачид, музейн ажилтнуудын хувь нэмрийг дэлгэн харуулж байна. Орос, Монгол хоёр улсын музейнүүд хийгээд судлаачид цаашид үр бүтээлтэй хамтран ажиллаж, танигдаж мэдэгдээгүй арвин баялаг соёлын өв сангийн үүдийг нээн дэлгэх нь дамжиггүй буй за хэмээн машид найднам.

Оросын Угсаатны зүйн музейн захирал,

ЮЛИЯ КУПИНА



ПРИВЕТСТВИЕ

Дорогие друзья,

Российский этнографический музей на протяжении всей своей истории служит благородной цели сохранения культурно-исторического наследия различных народов. Сегодня диапазон наших собраний уникален: более 530 тысяч единиц хранения, представляющие культуру народов России и сопредельных территорий, что ставит Российский этнографический музей в ряд крупнейших этнографических музеев мира.

Российский этнографический музей, как и многие культурные институции, решает сегодня сложную задачу — сохранить коллекции и одновременно сделать их доступными для самой широкой аудитории. Мы стремимся, чтобы наши коллекции были надежно защищены и в то же время доступны, чтобы они стали символом открытости не только самого музея, но и страны. Эти принципы являются краеугольными для сохранения уникальных музейных собраний и вводу музейных источников в глобальный информационный оборот. Поэтому изданию каталогов коллекций всегда отводилось важное место в деятельности музея.

Открытие собраний для представителей тех народов и стран, на территории которых коллекции собирались, - почетная и приоритетная задача современного этнографического музея. Поэтому наша особая благодарность и признательность руководству и сотрудникам Института истории и этнологии Монгольской Академии наук, при поддержке которого был подготовлен и издан настоящий каталог.

Значимым результатом совместного проекта стало осмысление научного наследия экспедиции Д.Э. Ухтомского 1913 года в Монголию и научное описание собранных им фотографий, что придает каталогу высокую научную и источниковедческую значимость.

Опыт и результаты нашей совместной работы мы с радостью представляем читателям всего мира, раскрывая вклад российских исследователей и музейных специалистов в познание и сохранение культурного наследия Монголии, открывая новый аспект богатого российско-монгольского культурного наследия, столь значимого сегодня для развития гуманитарного диалога стран и народов. Уверена, что дальнейшее творческое сотрудничество музеев и исследователей России и Монголии принесет еще много впечатляющих открытий.

ЮЛИЯ КУПИНА,

Директор Российского этнографического музея





ӨМНӨХ ҮГ

Монгол улсын Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбооноос эрхлэн "Монгол орон, Монголчууд" (Гэрэл зураг дахь Монголын түүх) цувралыг 2015 оноос эхлэн эрхлэн хэрэгжүүлээд байна. Энэ ажлын хүрээнд дэлхийн улс орнуудын архив, номын сан, музей, архивын сан хөмрөг, хувь хүмүүсийн цуглуулгад хадгалагдаж буй Монгол нутагт аялан ирсэн эрдэмтэн судлаачид, аялагчдын авсан гэрэл зургуудыг цуглуулж, эрж хайх, хамтран судлах, хуулбарлах, хэвлэн нийтлүүлэх ажлыг хэрэгжүүлж буй. Эдгээр гэрэл зургуудаас тухайн цаг үеийн Монголчуудын ахуй амьдрал, нүүдэл суудал, шашин шүтлэг, угсаатны зүй, газар нутаг, хувцас хэрэгсэл зэрэг зүйлсийг мэдэж болох боломжтой. Нэг ёсондоо эдгээр зургууд нь тухайн түүхэн цаг үеийн Монголчуудын ертөнцийн бодот тусгал, үнэ цэнтэй түүхэн эх сурвалж юм.

Энэ удаад тус цувралын VII боть болгон бид нар Оросын Угсаатны зүйн музейтэй хамтран тус музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Д.Э.Ухтомскийн тэргүүлсэн экспедицийнхэн 1913 онд Умард Монголд аялахдаа буулгасан гэрэл зургуудыг эмхтгэн эрдэм шинжилгээний тайлбарын хамт хэвлүүлж байна. Эдгээр зургуудын ихэнх нь анх удаагаа хэвлэгдэж, олон нийтэд хүрч буй бөгөөд тухайн цаг үеийн монголчуудын ахуй амьдрал, угсаатны зүй төдийгүй Монголын бурханы шашин, уран барилга, олон нийтийн амьдрал зэргийг судлах эрдэмтэн судлаачид, Монголын түүх соёлыг сонирхогч хэн бүхний үзэх үнэт эх сурвалж болох нь дамжиггүй юм. Орос Монголын өнө эртний уламжлалт соёлын харилцааны орчин цагийн нэгэн илрэл болж буй энэхүү гэрэл зургийн цомгийг хэвлүүлэн олон нийтэд хүргэх нөр их ажилд хамтран зүтгэсэн Оросын Угсаатны зүйн музейн эрдэмтэн судлаачид болон Монгол улсын Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн эрдэмтэн судлаачид болон хэвлэлийн эх бэлтгэхэд оролцон ажилласан бүх хүмүүст гүн талархлаа илэрхийлж байна.

Бид цаашид ч дэлхийн өнцөг булан бүрд хадгалагдан байгаа Монгол орон, монголчуудын өв соёлын дурсгалуудыг монголчууддаа, дэлхийн олон нийтэд хүргэхээр чармайн ажиллах болно. Монгол орон, монголчуудын өв соёлыг хүндэтгэн дээдлэгч та бүгдийн минь өлмий бат оршиж, Монголын өв соёл даян дэлхийд түгэн дэлгэрэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Монгол улсын Соёлын сайд, академич

САМПИЛДОНДОВЫН ЧУЛУУН

ПРЕДИСЛОВИЕ

Институт истории и этнологии Монгольской академии наук и Международная ассоциация монголоведения начиная с 2015 года издают серию фотоальбомов "Монголия и Монголы" (История Монголии в фотографиях). В рамках этой работы проводится поиск, совместное исследование, копирование и издание фотографических снимков исследователей и путешественников, посетивших в разное время Монголию, которые ныне хранятся в архивах, музеях, библиотеках и частных коллекциях по всему миру. На этих фотографиях запечатлены религиозные и этнографические сцены, одежда, домашняя утварь, перекочевки и стоянки, словом все, что отражает повседневный быт монголов. Благодаря этому изданию читатель может увидеть воочию ценные визуальные документы минувшего времени.

Настоящий фотоальбом, уже седьмой в серии публикаций, представляет фотографии снятые членами экспедиции Д.Э. Ухтомского в Северной Монголии в 1913 году, с научными описаниями и комментариями. Большинство из этих снимков публикуются впервые и несомненно несут огромную ценность для всех интересующихся историей и культурой монголов как первичные визуальные источники по религиозной и общественной жизни, архитектуре, археологическим памятникам Монголии и этнографическому быту монголов того времени. Мы благодарим наших партнеров из Российского этнографического музея за плодотворную работу над проектом совместно с сотрудниками Института истории и этнологии Монгольской академии наук и всех тех, кто принял участие в подготовке к публикации настоящего издания. Нужно отметить, что это плод и символ успеха Монголо-Российского культурного сотрудничества, имеющего давние традиции.

Мы и дальше будем неуклонно стремиться к тому, чтобы качественно публиковать и делать доступными для читателей памятники культурного наследия монголов, хранящиеся в разных уголках мира. Желаю крепкого здоровья и счастья всем кто любит монгольский мир и ее культурное наследие. Пусть развивается монгольская культура и ширятся ее горизонты, объединяя нас всех!

Министр культуры Монголии, академик

САМПИЛДОНДОВЫН ЧУЛУУН

1913 ОНД УМАРД МОНГОЛД Д.Э.УХТОМСКИЙН ЯВУУЛСАН ЭКСПЕДИЦ

Түүхэн нөхцөл байдал. Оросын музейн Угсаатны зүйн салбарын экспедицийн үйл ажиллагаа

Анх II Николай хааны зарлигаар 1895 онд III Александр хааны Оросын музейн Угсаатны зүйн салбар гэж байгуулагдаж байсан Оросын угсаатны зүйн музей нь эдүгээ Европын томоохон угсаатны зүйн музейнүүдийн нэгэнд тооцогддог. Д.Э.Ухтомский бол XX зууны эхэнд Угсаатны зүйн салбарын сан хөмрөгийг баяжуулж, ялангуяа тэр үедээ Оросын музейнүүд дотроо ч цорын ганц байсан, эдүгээ нийт 200 мянган гэрэл зураг (негатив болон позитив) бүхий эрдэм шинжилгээний гэрэл зургийн архивыг буй болгохоор зүтгэсэн судлаачдын нэг юм.

Дий Эсперович Ухтомскийн гэрэл зургийн цомгийг Оросын Угсаатны зүйн музейд буй монголчуудын уламжлалт соёлыг харуулсан гэрэл зургийн цуглуулгын дээж гэж хэлж болно. Түүний дөрвөн цуглуулгад байгаа 263 гэрэл зураг нь тус музейд байгаа монголчуудын соёлын холбогдолтой 380 гаруй гэрэл зураг бүхий цуглуулгын гуравны хоёр хувийг бүрдүүлдэг. Д.Э.Ухтомскийн гэрэл зургийн цуглуулгын бүрдсэн түүх нь XIX зууны төгсгөлөөс XX зууны эхэн үеийн Оросын олон нийтийн соёл, шинжлэх ухааны эрэлт хэрэгцээнд тулгуурласан Угсаатны зүйн салбарын үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм.

Угсаатны зүйн салбар байгуулагдсан цагаасаа л эхлэн Оросын өнцөг булан бүрийн ахуй амьдралыг харуулах чухал хэрэгсэл хэмээн угсаатны зүйн гэрэл зурагт онцгой анхаарал хандуулж байсан тул гэрэл зураг болон негативийн цуглуулганууд тус салбар байгуулагдсан цагаас л эхлэн цугларч иржээ. Мөн гэрэл зургийн цуглуулга бүрдүүлэх зорилгоор гэрэл зургийн аппарат худалдан авч, үүнээс хойш тус салбараас зохион байгуулсан экспедиц болон багахан аялалыг ч гэсэн боломжийн хэрээр гэрэл зургийн аппарат, ялтсаар ханган явуулах болжээ. Энэ үед музейнхэн голдуу өргөн хэмжээст дурантай Дерожи Зутер, Цейсийн камер болон Торноут-Пикарийн түгжээ,

Ильффорд Импрессион 9х12 хэмжээтэй шилэн негативийг ашиглаж байжээ (18х24 хэмжээтэй негативийг ховорхон ашиглаж байв)². Зураг авсан негативаа авчирж угаагаад бусад цуглуулгын хамтаар бүртгэн авна. Энэхүү аргагүй нь гэрэл зургийн архивын цаашдын хувь заяаг тодорхойлж өгсөн бөгөөд музей байгуулагдсан цагаас эхлээд л гэрэл зургийн угсаатны зүйн дурсгалын статустай болгосон тул гэрэл зургийн цуглуулгыг бүрдүүлэх арга болон тодорхойлолт бичих аргагүй нь эдийн соёлын дурсгалыг бүртгэх, цуглуулах аргатай ижил байсан юм.³

1903 оноос музейн гэрэл зургийн цуглуулгыг цогцоор бүрдүүлэх болж материал цуглуулах хамгийн сайн арга нь томилот юм байна гэж мэдэв. Угсаатны зүйн салбарын ажилтнууд экспедицийн үеийн судалгааны ажил, ялангуяа гэрэл зураг авах аргагүйн үндсийг тавьсан “Угсаатны зүйн эд зүйлсийг цуглуулах хөтөлбөр”-ийг тусгайлан боловсруулжээ⁴. Энэхүү хөтөлбөрийн ёсоор суурин, гэр байшин, орон сууц, эд зүйлс, хувцас чимэглэл, ардын амьдрал дундах оньс техник, хоол хүнс, ажил хөдөлмөр, гэр ахуй, сүсэг бишрэл, мэргэ төлөг, ардын эмнэлэгийн зүйлийг гэрэл зурагт буулган авах ёстой байв. Музейн ажилтнууд болон тэдний сурвалжлагч нарын хээрийн шинжилгээний үеэр амжилттай хэрэгжүүлж байсан хүн судлалын хэмжил зүйн ажлын аргазүйг боловсруулахад Санкт-Петербургийн их сургуулийн багш, профессор олон арван алдартай угсаатны зүйч хүн судлаачдын багш, 1904-1906 онд Угсаатны зүйн салбарын сурвалжлагч, 1907-1918 онд хадгалагчаар ажиллаж байсан Ф.К.Вовк (Волков)-ийн оруулсан хувь нэмэр маш их юм. Тэрбээр “хээрийн шинжилгээний анги буусны дараа музейн зүгээс

2 Соловьева К. Ю. Образы Югры в ранней русской фотографии // ОБИгатели. Образы Югры в ранней русской фотографии. Санкт-Петербург; Сургут: [б.и], 2004 С. 6–9.

3 Соловьева К.Ю. Этнографическая фотография: опыт репрезентации в контексте прошлого и настоящего (по материалам Российского этнографического музея) // Эхо арктической одиссеи: судьбы этнических культур в исследованиях ученых-североведов: сборник материалов всероссийской научно-практической конференции с международным участием, 14-15 ноября 2019 г. Якутск: Электронное издательство НБ РС(Я), 2019. С. 343-353.

4 Программа для собирания этнографических предметов. Санкт-Петербург, 1902.С. 1-9.

1 Федорова М.В. Монгольские фотоколлекции конца XIX – начала XX в. в собрании Российского этнографического музея как источник для изучения традиционной культуры монголов // Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов. Четвертая международная конференция. 18– 19 апреля 2019 г. Программа, тезисы. Улан-Батор: Институт истории и археологии МАН, Международная Ассоциация монголоведов (МММ), ИВР РАН, 2019. С. 59 – 61.

шинжилгээний ангид оролцогчдоор угсаатны зүйн цуглуулгын тодорхой бүртгэлийг хийлгэдэг тул угсаатны зүйн ажиглалтаар нэмж баяжуулсан гэрэл зураг авах нь бэлтгэгдсэн сайн угсаатны зүйчдийг хүмүүжүүлэх сайн дадлага туршлага болж өгдөг” хэмээн тэмдэглэсэн байдаг⁵. Тийм учраас музей байгуулагдсан эхний үед хээрийн шинжилгээний анги нь батлагдсан хөтөлбөрийн дагуу материал цуглуулж, гэрэл зураг авч, хүн судлалын хэмжилзүйн судалгаа, үзүүлэн бүрдүүлэх ажлыг хийж байв.

Угсаатны зүйн салбарын анхны эрхлэгч Д.А.Клеменцийн удирдлагаар “онцгой эрх ашиг, соёлын асар их ач холбогдол бүхий” нүсэр том зорилгодоо хөтөлгөдсөн тус салбарын ажилтнууд шинэ музейгээ Оросын олон арван эрдэмтдийн сэтгэлийг татсан газар болгож чаджээ⁶. Д.А.Клеменц «Тус музейн угсаатны зүйн салбар нь өөрөө аль эртнээс Оросын шинжлэх ухаан, үндэсний оюун санааны эрх ашгийн үүднээс үгүйлэгдэн буй Оросын Төв музей болж хувирах ёстой. Хуучин тивийн бүхий л умард, зүүн хойт нутгаар тоймгүй олон янзын ахуй амьдралын нөхцөл байдалд дасан зохицож, өөрийн онцлог байдлаа хадгалан үлдэж чадсан далан сая оросуудын эх орон Орос гүрэн өөрөө оюуны болон эдийн соёлын онцлогийн олон шинж байдлыг агуулдаг. Соёлын хөгжлөөрөө хоорондоо өдий төдий ялгаатай Оросын харьяаны болон хил дагуух газар орны харь овог аймгууд ч гэсэн бага бус сонирхол татаж байна»⁷ гэж бичсэн байдаг. Тус музей нь XIX – XX зууны эхэнд Орос болон дэлхий дахинд болж байсан үйл явц, ялангуяа Оросын эзэнт гүрэн Төв, Зүүн Азийн улс, ард түмнүүдтэй улс төр, эдийн засаг, соёлын хувьд ойртон нягтарсан үйл явцын үр дүнд үүссэн нөхцөл байдалтай холбогдсон нийгэм-улс төрийн эрэлт хэрэгцээг соргоогоор мэдэрч үйл ажиллагаандаа тусгаж байв.

XIX зууны төгсгөл XX зууны эхээр Оросын дорно дахин судлалд жинхэнэ “алтан үе” эхэлсэн бөгөөд энэ үеийн дорно дахин судлалын дэг сургуулийн хамгийн том төлөөлөгчид нь И.П.Минаев, Ф.И.Щербатской, С.Ф.Ольденбург, Б.Я.Владимирцов, В.В.Радлов болон бусад том эрдэмтэд байсан юм. Оросын Шинжлэх ухааны академи болон Оросын Газар зүйн нийгэмлэг Төв Ази, Монгол, Умард Хятад, Төвдөд томоохон хээрийн шинжилгээний судалгааны ангиудыг илгээж XIX зууны төгсгөл XX зууны эхээр Н.М.Пржевальский, Г.Н.Потанин, В.А.Обручев,

5 Ивановская Н.И. Сергель и его научное наследие //Сергей Иванович Сергель. Этнограф и путешественник / Авт.-сост. Н.И. Ивановская, А.А. Чувьюров. СПб., 2011.С. 18.

6 Могилянский Н.М. Этнографический отдел Русского музея Императора Александра III // Живая старина. 1912. Вып. 2.С. 495.

7 АРЭМ. Ф.1 Оп.1. Д. 5, Л.7.

Г.Е.Грум-Гржимайло, П.К.Козлов нарын аялагч-судлаачид энэ бүс нутгийн судалгаанд ихээхэн хувь нэмрээ оруулжээ⁸. 1907–1909 онд П.К.Козловын удирдсан Монгол-Сычуаний экспедиц нь Говиос “мөхсөн” хот Хар хотыг нээн илрүүлж, ховор чухаг археологийн дурсгалуудыг олж нээв. Тус экспедиц нь үүний хажуугаар монгол, төвд, хятадуудын буддын шашны шүтлэг, угсаатны зүйн үнэт цуглуулгыг бүрдүүлэн цуглуулсныг 1911 онд II Николай хаан худалдан авч Оросын музейн угсаатны зүйн музейд бэлэглэжээ (1930-аад онд тус цуглуулгын ихэнхийг Эрмитажид шилжүүлэв).

Орос-Японы дайны (1904–1905) дараа Оросын эзэнт гүрэн төдийгүй Дайчин улс ч Монголд анхаарлаа хандуулах нь ихэсч тэндэх үйл ажиллагаагаа идэвхжүүлэв. Өөрийн эрх ашгаас гадна давхар америк, европын түүхий эд олборлогчдын эрх ашгийг төлөөлөх болсон хятад худалдаачдын нөлөө Монголд ихэсч, тэнд тогтоогоод байсан Оросын худалдаа-эдийн засгийн харилцаа холбоо суларсан нь, ихээхэн санаа зовоох асуудал болж, Оросын талаас Монгол дахь улс төр, худалдааны нөлөөгөө бэхжүүлэх, Монголыг бүхий л талаас нь судалж шижлэх зорилготой олон экспедицүүдийг томилон явуулж эхлэв. Түүний нэг нь 1910 онд нэрт аялагч хурандаа В.Л.Поповын тэргүүлсэн Москвагийн худалдааны экспедиц болно⁹. Тус экспедицийн хүрээнд хуурай болон усан замын тээвэр, Монголын бүс нутаг, худалдааны төвүүд, хүн ардын аж ахуй (ахуйн хэрэгцээг нь оролцуулаад), засаг захиргааны зохион байгуулалт, худалдаа наймааны шинж, Монгол дахь оросуудын эрх зүйн нөхцөл, бодит байдал зэргийг судалж, Монгол дахь оросын худалдааг амжилттай хөгжүүлэхийн тулд Орос-Чингийн худалдааны гэрээнд (Монгол нь энэ үед Чин улсын бүрэлдхүүнд байсныг санах хэрэгтэй) ямар өөрчлөлт оруулбаас зохистой болохыг судалжээ. Экспедиц баялаг материал цуглуулж чадсан нь, удалгүй Монгол улс Чингийн бүрэлдхүүнээс салан гарч буй нөхцөлд хамтын ажиллагааг цаашид аль зүгт хандуулахыг тодорхойлох боломж гаргаж өгсөн байна.

Төв Азид өөрийн байр сууриа бэхжүүлэхэд чиглүүлсэн Оросын бодлого хийгээд Ази дахинд явуулсан Оросын дорно дахин судлаачид, аялагчдын өргөн далайцтай шинжилгээ судалгааны ажил нь Оросын музейн Угсаатны зүйн салбараас Дорно дахины ард түмнүүдийн соёлын дурсгалыг анхааран цуглуулж судлах ажлыг өөрийн

8 Андреев А.И., Гнатюк Т.Ю., Кожевникова М.Н. Российские экспедиции в Центральную Азию: организация, полевые исследования, коллекции. 1870–1920 гг. СПб.: Нестор-История, 2013. 332 с.

9 Московская торговая экспедиция в Монголию. Москва, Типография П.П. Рябушинского. 1912. С.1-24.

судалгаа шинжилгээний чухал нэгэн чиглэл болгохын үндэс болсон байна. Энэхүү идэвхитэй үйл ажиллагааны үр дүнд Оросын угсаатны зүйн музейд Төв Азийн ард түмнүүдийн уламжлалт соёлын эд өлгийн зүйлс, гэрэл зургийн баялаг цуглуулга бүрэлдэн буй болсны дотор Д.Э. Ухтомскийн хүчин чармайлтын үр дүнд анхлан буй болсон Монголын түүхэн гэрэл зургуудын цуглуулга хүндтэй байр суурийг эзэлдэг.

Д.Э.Ухтомскийн намтар (1886–1918)

Дий Эсперович Ухтомский 1886 оны 8 сарын 20-нд Петербург хотноо XIX зууны төгсгөл XX зууны эхний Орос орны соёл, шинжлэх ухаан, улс төрийн амьдралд гүнзгий үл мөрөө үлдээсэн нэр алдартай дорно дахин судлаач Эспер Эсперович Ухтомский вангийн гэрт төржээ.

Ухтомский вангийнхан эртний уг шагтай улс юм. Эцгийн талаараа Рюрикийн угсаа Мономахийн удам Ростов-Белозерийн ноёд болно. Ухтомскийн дээдэс дотор Чингис хааны ач Бат хаан, Владимир Всеволодович Мономахийн зургадугаар хүү Киевийн их ван Юрий Долгорукий зэрэг нэртэй хүмүүс байв. Д.Э.Ухтомскийн эмэг эх Женни Алексеевна нь II Екатерина хатан хааны үеийн алдартай адмирал, Чесмений тулалдааны баатар С.К.Грейгийн хойчис нэр хүндтэй шотланд гэр бүлээс гаралтай хүн байжээ.

Дий Эсперович 8-р анги хүртлээ гэрийн сургуулиар олон талт гялалзсан боловсрол хүртэж, гурван ч гадаад хэл эзэмшсэн бөгөөд Нэгдүгээр Гимнази, Александрын лицейд сурч төгсгөжээ. Багаас дэлхий дахиныг тойрон аялж, Өрнөд Европ, Крымд хүрч, 14-15 насандаа эцэг эхийн хамт дэлхийг тойрон аялж, Америк, Хятад, Сингапур, Цейлон, Египетэд очиж үзсэн байна.

Д.Э.Ухтомский хархан бага наснаасаа эхлэн дорно дахины ард түмний соёл, шашныг сонирхон судалж, урлаг гоо сайхан хийгээд эрдэм шинжилгээний өндөр үнэ өртөгтэй бурхны шашны эд зүйлсийг хураан цуглуулж, орчин тойронд нь байлгасан судлаач эцгийнхээ нөлөөн дор хүн болж төлөвшин хүмүүжжээ. Дий хүүг багаас нь мэдэх Э.Э.Ухтомскийн найз академич С.Ф.Ольденбург: «Буддын музей болгон хувиргасан их танхимд байх бурхадын утга учрыг тайлбарлахыг анхааралтай сонсч, учрыг нь олохоор эрмэлзэж буй хүүгийн царай төрхийг нь саяхан мэт санаж байна. Петербургийн баруун этгээдэд буй энэхүү Дорно дахины бяцхан өнцөг буланд байгаа орчин тойрон лугаа жаал хүүгийн өндөр, сайхан бие гайхалтай сайхан зохицох гэж. Хүү энэ бүх бурхан, бодисад нарын дунд өсч хүн болсон болохоор энэ газар залуу Ухтомскийн насан туршийн амьдралд арилшгүй

үл мөрөө үлдээсэн гэж санадаг»¹⁰ гэж бичиж үлдээсэн байдаг.

Дий Ухтомскийн өсч торнисон орчин тойрон ийм байсан тул хар багаасаа л бурхны шашин, Дорно дахины угсаатны зүй, археологийг сонирхох болсон нь түүний цаашдын хувь заяаг шийдвэрлэжээ. Эрдэм шинжилгээ, музейн дур сонирхолтой ажилдаа ямар ч ашиг хонжоо харалгүй оролцож явах нь л түүний хүсэл байв.

1907–1908 онд Э.Э.Ухтомский хүүгээ Оросын музейн Угсаатны зүйн салбарт оруулахаар өргөдөл гаргажээ. Эспер Эсперович өөрийн сайн нөхөр Оросын музейн эрхлэн захирагч гүн Д.И.Толстойд ийн бичсэн байдаг: «Энэ жил миний хөвүүн лицей сургуулиа дүүргэх байнам. Зураг урлал, археологи, угсаатны зүйд их л сонирхолтой тул би хөвүүнээ танай газар Клеменц авгайн салбарт оруулах хүсэлтэй байна. Цалин мөнгө, орон тоо эрж бусад хүнд саад болохгүй байхыг хүсч байгааг минь ойлгох ажааму. Дмитрий Александрович лугаа энэ хэргийг хэлэлцэлгүй танд хандахаас зүрхшээж, юуны өмнө Клеменц авгай лугаа уулзаж асуусанд тэрбээр хөвүүнийг минь сайн таних тул бүрнээ зөвшөөрөв. Иймийн тул би эдүгээ танд шууд хандаж байна. Миний хөвүүн гурван ч гадаад хэл мэдэх бөгөөд музейн зүгээс хөвүүнийг минь харь гүрэн буюу хязгаар оронд (Клеменц авгай Байгалын чанад хязгаарт явуулсугай хэмээмү) томилон илгээхүл өөрийн мөнгө зардлыг хэрэгсэн явж чадмуй. Миний хураасан Дорно дахины цуглуулгын дунд өсч том болсон учир өчүүхэн төдий зүйлийг ч алдалгүй сайн мэдмүй...»¹¹. 1908 оны 4 сарын 14-нд илгээсэн захидалдаа Э.Э.Ухтомский хүүгээ Угсаатны зүйн салбарт авахыг дахин хүсч, «миний хүү эцгийнхээ өдий олон жил хураасан цуглуулгыг хадгалан буй музейд албаны мөнгө цалин, орон тоог өчүүхэн ч халдалгүй судалгааны ажил хийхийг л хүсэн буй <...> Хүү минь цалин мөнгө авалгүй хаа яв хэмээсэн газар одож, сурч чадмуй. Хувь заяаны эрхээр музейн босгоор өөрөө алхан ороход бэлэн болсон ийм нэгэн хүнийг дэмий учиргүй ажилд авахгүй аваас юутай гомдолтой хэрэг болох билээ...»¹² хэмээн бичжээ.

Ингээд 1908 онд Д.Э.Ухтомский Оросын музейн Угсаатны зүйн салбарт ажилд оржээ. Эхний өдрөөсөө л Угсаатны зүйн салбарын анхны эрхлэгч бөгөөд насан турш угсаат-

10 С.Ф. Ольденбург. Памяти Дия Эсперовича Ухтомского [1918 г.]. УА РГО.Р. 110.Оп. 1. № 42.Л. 1-4 (Цит. по: Дмитриев С.В. Фонд Этнографического отдела Русского музея по культуре народов зарубежного Востока... С. 328)

11 РГИА.Ф.696. Оп.1. Ед. хр. 617. Л. 6-6об. (Цит. по: Дмитриев С.В. Фонд Этнографического отдела Русского музея по культуре народов зарубежного Востока... С. 333).

12 Там же. Л.1об-2 (Цит. по: Указ.соч. С. 333).

ны зүй, археологийн судалгаа хийж, амьдралынхаа утга учрыг болгосон их эрдэмтэн Д.А.Клеменцийн удирдлагад ажиллах завшаан тохиосон байна. Д.А.Клеменц ч Дий Ухтомскийн бурхны шашны мэдлэг, сонирхлыг нь ашиглан түүнийг тэр даруй Байгалын чанад мужид томилон музейд зориулан Тамчийн дацанд бүтээлгэсэн Амитаба бурхны ариун орон Диваажингийн загварыг авчруулахаар илгээв. Энэ загварыг Э.Э.Ухтомскийн хүсэлтээр (4000 рублийн ханштай болжээ) цанид хамба Агван Доржиев нутгийн дархчуулаар үйлдүүлсэн байсан нь 1905 оны 5 сараас хойш XI бандида хамба лам Чойнзондорж Иролтует Тамчийн дацанд хадгалагдаж байсан аж. Өөрийн эзэмших эрхээ Эспер Эсперович Оросын музейн Угсаатны зүйн салбарт шилжүүлэн өгч, 1908 оны намар Д.Э.Ухтомский Диваажингийн загварыг Угсаатны зүйн салбарт авч ирсэн байна¹³. Эхний даалгавраа амжилттай биелүүлсэн Дий Эсперович дараа нь бурхны шашны урлагийн энэхүү үнэ цэнтэй дурсгалын тухай өгүүлэл бичиж «Материалы по этнографии России» (Оросын угсаатны зүйн эх хэрэглэгдхүүн) хэмээх музейнхээ эмхэтгэлийн нэгдүгээр ботид хэвлүүлжээ¹⁴. Энэ томилолынхоо үеэр Д.Э. Ухтомский мөн Угсаатны зүйн салбарын даалгавраар Тамчийн дацанд зураг авснаа буулгаж цомог болгон авчирсан нь эдүгээ хүртэл хадгалагдаж ирэв¹⁵.

1910 болон 1913 онд Д.Э.Ухтомский Угсаатны зүйн салбарын даалгавраар Умард Монголд хоёр экспедиц толгойлон явж, олон тооны угсаатны зүйн эд хэрэглэгдхүүн, гэрэл зургийн цуглуулга хийн авчиржээ.

Москвагийн худалдааны экспедицтэй бараг нэгэн цаг хугацаанд шахуу Чин улсын бүрэлдэхүүнд байсан Монгол орноор Д.Э.Ухтомский анх удаагаа аялан Түшээт хан аймгийн хойд болон зүүн хэсгээр, Сэцэн хан аймгийн зүүн-өмнөд хэсгээр дайран явсан байна. Энэ аяллынхаа үеэр Дий Эсперович халх монголчууд хийгээд Хүрээнд суугаа төвөд хүмүүс (андуу нар хийгээд монголчуудын хар тангад хэмээн дууддаг банаг нарын) дунд цуглуулга хийж, бурхны шашны эд өлгийн зүйл нийт 234 цуглуулжээ¹⁶. Энэ бүх зүйлс нь дараа нь Угсаатны зүйн салбарт бүртгэгдэн хадгалагдаж, эдүгээ тус музейн Төв Азийн ард түмнүүдийн уламжлалт соёлыг харуулсан цуглуулгын

13 Переписка с кн. Э.Э. Ухтомским о коллекции «диваджина», заказанной у забайкальских мастеров. 1905–1913. АРЭМ. Ф.1.Оп.2. Д. 642. Л. 2-2об, 9.

14 Кн. Д.Э. Ухтомский. Рай Сукавати // Материалы по этнографии России / под ред. Ф.К. Волкова. Т. I. СПб.: Издательство Этнографического отдела Русского музея императора Александра III, 1910. С. 89-92.

15 Колл. РЭМ № 3041 (рег. В. Васильев. 1914)

16 АРЭМ.Ф.1. Оп.2. Д. 641.Л. 7-19.

нэлээд хэсгийг эзэлж байна¹⁷.

1913 онд Чин улсын бүрэлдхүүнээс нэгэнт гарч, тусгаар тогтнолоо зарласан Монгол орноор Д.Э.Ухтомский аялахдаа Оросын эзэн хааны ордны камер-юнкер болоод байв. Энэ аяллынхаа үеэр монголчуудын соёлыг дэлгэн харуулсан ховор нандин гэрэл зургийн цуглуулга бүрдүүлж ирсэн нь бидний хэвлүүлэн буй энэхүү цомог билээ. Энэ экспедицийнх нь тухай доор тусгайлан өгүүлнэ.

1912 онд Д.Э.Ухтомский Угсаатны зүйн салбарын даалгавраар «Монголын Түшээт хан болон Цэцэн хан аймгийн нутагт уурхай эрхлэх Оросын хувьцаат нийгэмлэг» (Монголор)-ийн захирал агсан Виктор Юлиевич фон Гротын хятад, монголын эртний эдлэл болон бурхны шашны эд зүйлсийн алдартай цуглуулгыг нь Бээжингээс авч Петербургт хүргэж иржээ. Алт олборлодог энэхүү хувьцаат нийгэмлэгийн үндсэн хувьцаа эзэмшигчдийн нэг нь Дий Эсперовичийн эцэг Э.Э.Ухтомский ван байсан билээ. Ухтомский хийгээд фон Гротынхны гэр бүлийн дотно харилцаа нь энэ даалгаврыг амжилттай биелүүлэхэд тус дөхөм болжээ¹⁸.

Экспедицэд явахынхаа завсраар музейдээ ажиллаж, академич С.Ф. Ольденбург болон Угсаатны зүйн салбарын бусад ажилтнуудын удирдлагаар музейд буй буддын шашны цуглуулгыг судлан, бүртгэж байв. 1914 онд музейд байгаа өөрийн эцгийн цуглуулгын хадгалагч болж, 2061 эд зүйл бүхий тус цуглуулгын бүртгэлийг үйлджээ.

Дэлхийн нэгдүгээр дайн эхэлснээр Дий Эсперович Петроградын Улаан загалмайн нийгэмлэгийн захиргаанд шилжин ажилласан бөгөөд 1916 онд Баруун-Өмнөд фронтын Улаан загалмайн тэргүүн отрядын даргаар томилогдон очив. «Шархдагсдыг тэргүүн шугамаас үүрэн гаргаж явтал нь, түүний дэргэд хорт хийн бөмбөг дэлбэрч, хэзээнээс өвчилсөн сүрьеэ нь улам хүндэрчээ»¹⁹. Гэвч Ухтомский ар тал руу халагдахыг хүссэнгүй 1918 онд л сая хүнд өвчтэй Москвад буцаж ирж, эхнэр Н.Д.Цертелева болон Дмитрий, Алексей, Марианна гурван хүүхэдтэйгээ уулзав. Тэр үеэр хотод өлсгөлөн болж, хүнд өвчтэй Д.Э. Ухтомский удаан тэссэнгүй 1918 оны 10 сард өөд болжээ.

17 Колл. РЭМ № 1898, 1899, 2933, 3837, 3841.

18 Дмитриев С.В. Князь Д.Э. Ухтомский и его деятельность в Этнографическом отделе Русского музея императора Александра III // Кюнеровский сборник: Материалы Восточноазиатских и Юго-Восточноазиатских исследований. Этнография, фольклор, искусство, история, археология, музееведение. 2008–2010. Вып. 6. СПб.: МАЭ РАН, 2010. С. 91.

19 С.Ф. Ольденбург. Памяти Дия Эсперовича Ухтомского [1918 г.]. УА РГО, р. 110, оп. 1, № 42, л. 1-4 (Цит. по: Дмитриев С.В. Фонд Этнографического отдела Русского музея по культуре народов зарубежного Востока... С. 331).

Түүний эх орныхоо өмнө байгуулсан гавьяа зүтгэлийг нь үнэлж Гэгээн Станиславын III зэргийн одон, Гэгээн Аннагийн III зэргийн одонгоор тус тус шагнажээ.

«Дий Эсперович Ухтомскийн дурсгалд» хэмээх эмгэнэлийн үгэндээ С.Ф.Ольденбург, түүний Монгол орноор аялан явсныг өгүүлэхдээ «залуу Ухтомский аян замдаа үзсэн харснаа хэрхэн амьдлагаар дүрслэн ярьж» байсныг дурсаад «Бид соёлын дурсгалт зүйлээ аймшигтай муу хадгалж үлдээх юм: Манайд аялагч судлаачид нас барлаа л бол тэмдэглэл, бичиг цаас нь үрэгдэж алга болдог шиг энэ залуугийн тэмдэглэл бүү үрэгдчихээсэй билээ. Олон сонирхолтой нээлт, ажиглалт хийсэн нь шинжлэх ухаанд үлдэж хоцроосой гэж санах юм»²⁰ гэж бичжээ. Харамсалтай нь, Д.Э.Ухтомскийн 1913 онд Монголд явсан экспедицийн тэмдэглэл эдүгээ хаана байх нь тодорхойгүй байна. Шинжлэх ухааны үнэ цэнтэй энэ баримт Оросын угсаатны зүйн музейн сан хөмрөгт ч алга, Оросын Холбооны улсын бусад архивуудаас ч олноогүй байна. Зөвхөн албаны болон хувийн захидал харилцаа, Угсаатны зүйн салбарт өгсөн товч тайлан, Угсаатны зүйн салбарын зөвлөлийн хурлын тэмдэглэл, экспедицийн материалаар А.З.Носовын бичсэн хоёр илтгэл л үлдэж хоцорчээ²¹. Экспедицийн замыг өөрийн нүдээр мөрдөн тогтоох гол сурвалж нь Д.Э.Ухтомскийн Монголоос авчирсан гэрэл зургийн цомог болно. Энэ цуглуулгын зургуудыг 1929—1930 он Е.П.Орлова бүртгэж, товч тайлбар үйлдэхдээ одоо музейн сан хөмрөгт байхгүй Д.Ухтомскийн тэмдэглэлүүдийг ашигласан бололтой. Энэ мэт сурвалжийн үндсэн дээр экспедицийн маршрутыг сэргээн тогтоож, түүхийг нь тодруулах боломжтой болсон юм (мөн тодорхойгүй зүйл ч нэлээд үлдсэнийг хэлэх хэрэгтэй).

Д.Э.Ухтомскийн 1913 онд Умард Монголд хийсэн экспедиц ба цуглуулсан гэрэл зургийн цомог

1913 онд Угсаатны зүйн салбарын хувьд санхүүгийн хүндрэлтэй тулгарч Сибирь болон Алс дорнодод музейн сан хөмрөгийг баяжуулах экспедиц томилон явуулж чадахгүйд хүрчээ. Угсаатны зүйн салбарын тус жилийн тайланд: «Тус тайлангийн жилд төсөвлөсөн зардлын ихэнх нь өмнөх жилийн материал цуглуулах ажлын

20 Мөн тэнд С. 330.

21 Носов А. «Петроглифи з долини р.Орхон (Монголия)» // Антропология. Річник кабінету. Киев: Українська Академія наук. Кабінет Антропологиї ім. Ф. Вовка. 1928. С. 135-142; Он же. К антропологии монголов-халхасцев (contribution à l'anthropologie des Mongols-khalkhas). (Предварительное сообщение). Отдельный оттиск из V т. Ежегодника Русского антропологического общества при Императорском Петроградском университете / под ред. С. И. Руденко. Петроград: Типография «К. Биркенфельд», 1915. С. 109 – 116.

нэмэлт санхүүжилтэд орчихсон тул энэ жил Сибирь лүү материал цуглуулахаар хүн илгээх нь ихээхэн бэрхшээлтэй тулгарав. Үлдсэн мөнгөөр нь материал цуглуулах ямар ч томоохон экспедиц гаргах боломжгүй байсан тул урьд цуглуулсан зүйлсийн дутууг нөхөх маягаар л аргацаан өнгөрүүлжээ. Музейн ажилтан болсон Д.Э.Ухтомскийн вантан А.З.Носов, П.А.Смелов нарын хамт өөрийн хөрөнгө мөнгөөр Зүүн-хойд Монгол оронд аялан явж ирсэн нь Салбарыг дээрх хүндрэлтэй байдлаас гарахад тус болов»²².

Д.Э.Ухтомскийн умард Монголд хийх экспедицийг 1913 оны зун хийхээр төлөвлөж, бүрэлдхүүнд нь Ф.К. Волковын шавь антропологич Анатолий Зиновьевич Носов болон археологич Павел Алексеевич Смелов нар багтжээ.

Д.Э.Ухтомский энэ удаа мөн л түрүүчийнх шигээ (1910 он) – Түшээт хан аймаг болон Цэцэн хан аймгийг Хүрээний хамт сонгон авсан нь санаандгүй хэрэг биш байв. Дээр хэлсэнчлэн Дий-гийн эцэг Э.Э.Ухтомский Монголорын хувьцаа эзэмшигч бөгөөд удирдлагынх нь нэг байсан юм. Магадгүй энэ болон өмнөх экспедицийн үеэр Монголороос үүсэлтэй харилцаа холбоог ашиглах буюу тус хувьцаат нийгэмлэгийн зарим нэг үүрэг даалгаврыг биелүүлэх зорилготой явсан байж болно²³.

А.З.Носов хожим өөрийн өгүүлэлдээ экспедицийн зорилгыг товчхон дараах маягтай тодорхойлжээ: «1913 онд надад нэртэй судлаач Д.Э.Ухтомский агсны зохион байгуулсан экспедицид оролцох хувь тохиосон юм. Экспедицийн зорилго нь тухайн үеийн Орос Монголын худалдаа болон бас бус харилцаанд ашиглах зам харилцааны нэг болгон Сэлэнгэ мөрний баруун талаас цутгадаг Орхон голд усан онгоцоор явж болох эсэхийг судалж, дагууд нь монголчуудын угсаатны зүй, антропологийн материал цуглуулах байсан юм». Тэгэхлээр энэ бол тандалтын экспедиц байсан гэж хэлж болно. Экспедицийн оролцогчид угсаатны зүй, археологи, антропологийн материал цуглуулах үндсэн зорилгоосоо гадна Орос-Монголын худалдаа-эдийн засаг, соёлын харилцаа холбооны замыг нээх давхар даалгавартай явжээ. Экспедицид гарахаасаа өмнө Дий Эсперович эхнэр, нөхөр Потанин болон П.К.Козлов зэрэг Төв Ази судлаачдын экспедицийн тайлан, ном бүтээлээс гадна 1910 онд Монголоор явсан В.Л.Поповын 1912 онд хэвлэгдсэн тайланг нарийн нягталж үзсэн нь дамжиггүй.

22 АРЭМ. Ф. 1. Оп. 1. Д. 80. Отчет Этнографического отдела Русского музея императора Александра III за 1913 г. / Из общего отчета Русского Музея Императора Александра III. Петроград: Типо-литография «Энергия», 1914. С. 11.

23 Дмитриев С.В. Фонд Этнографического отдела Русского музея по культуре народов зарубежного Востока... С. 336.

Д.Э.Ухтомскийн экспедицийн нэг гол зорилт нь угсаатны зүй, археологийн объект, газар орны тогтоц, зам харилцаа, голын олом гарам, уран барилгын дурсгал, нутгийн ард иргэдийн байр байдлыг гэрэл зурагт буулгах байжээ. Экспедицийн оролцогчид бүгдээрээ л гэрэл зураг авах дадлага туршлагатай хүмүүс байв. Оросын Угсаатны зүйн музейд Д.Э.Ухтомскийн 1908 онд Буриадад явсан экспедицийн гэрэл зургууд²⁴, П.А.Смеловын 1911 онд Оросын төв мужуудаар явсан экспедицийн гэрэл зургууд²⁵, А.З.Носовын 1911-1912 онд Сербид явсан экспедицийн гэрэл зургууд хадгалагдаж байна²⁶. А.З.Носов 9x12 см хэмжээтэй шилэн негатив ашигладаг бол А.П. Смелов адилхан шилэн негатив ашигладаг боловч тэр нь 13x18 см хэмжээтэй, харин Д.Э.Ухтомский негатив хальс ашигладаг байжээ²⁷. Архивын материалыг үзвэл Д.Э.Ухтомский болон А.З.Носов нар өөрсдийн хувийн аппаратаар (гэхдээ музейн олгосон дуранг ашигладаг байсан байх боломжтой) гэрэл зураг авч байжээ²⁸.

Экспедицийн бэлтгэл ажил хавар эхэлсэн байна. 1913 оны 5 сарын 18-нд болсон Угсаатны зүйн салбарын зөвлөлийн хурал дээр Д.Э.Ухтомский ван «Байгалын чанад муж ба Монголд экспедицээр явах томилолтын хуудас олгож, Эрхүүгийн генерал-губернатор, Читийн губернаторт тус экспедицийн ажилд тусламж дэмжлэг үзүүлэх тухай бичиг илгээх өгөх»-ийг хүссэнийг зөвлөлийн шийдвэрээр зөвшөөрч шийдвэрлэж өгчээ²⁹.

Дий Ухтомский экспедицдээ шинэ маягийн тээврийн хэрэгсэл моторт завь авсан нь бараг анх удаа Монголд моторт завиар аялсан тохиолдол болсон болов уу. «Гэр бүлд нь үе дамжин ирсэн домгийг үндэслэн Белозерскийн Мономахийн угсааны вангуудын элэнц эх болсон Чингис хааны удмын Сартаг ноёны охины дурсгалыг хүндэтгэн моторт завиа «Сартак» гэж нэрлэжээ»³⁰. Урт замыг туулах хань болох учиртай тэрхүү моторт завиыг нь, экспедицийн аяны гараа болох Дээд Үд хот хүртэл

24 РЭМ, колл. 3041.

25 РЭМ, колл. 2187, 2188, 2210, 2211, 2212, 2213, 2214.

26 РЭМ, колл. 2537, 2539, 2540, 2694; см. подробнее: Михайлова А.А. Вклад А.Носова в формирование сербских коллекций РЭМ // Этнографические коллекции в музеях: культурные стратегии и практики. СПб., 2013 С. 196–202.

